

Бат-Өлзий сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2022 оны 10 дугаар сарын 10-ны  
өдрийн **я** тогтоолын хавсралт

**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ**  
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДУРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

УЛСЫН ГАЗРЫН ХЭРЭГЖКҮҮЛЭЛЧ АГЕНТЛАГ УЛСЫН БҮРТГЭДИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР	
УЛСЫН БҮРТГЭЛИЙН 1088001018 дугаар	
БҮРТГЭВ 2023 он 05 сар 19 одор	

1.1. Бат-Өлзий сумын тохижилт үйлчилгээ Улсын төсөвт үйлдвэрийн газар нь орон нутгийн өмчийн өөрийн балансад бүртгэгдсэн эд хөрөнгө, дүрмээр хүлээсэн үүргийн хүрээнд улс орон нутгийн төсвөөс олгогдсон хөрөнгө оруулалтаар болон бусад үйл ажиллагааны орлогоор санхүүжих замаар бие даан иргэний гүйлгээнд ордог орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбай, тохижилт, ногоон байгууламж, автозам, парк, хүүхдийн тоглоом, гуурин засвар үйлчилгээг хариуцан хамгаалах, гэрэлтүүлэг засвар, ойн цэвэрлэгээнд гарах, хайрганы төвлөрсөн цэгтэй болох, сумын доторх такси үйлчилгээ, хог хаягдлын менежментийг нэгдсэн удирдлагаар хангах, төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг эрхлэх, үйлчилгээний бүх төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, засварлах үйлчилгээг үзүүлэх, удирдан чиглүүлэх Бат-Өлзий сумын тохижилт үйлчилгээний улсын төсөвт үйлдвэрийн газар мэн.

1.2. Бат-Өлзий сумын Тохижилт үйлчилгээ Улсын төсөвт үйлдвэрийн газар /цаашид Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ гэнэ/ нь үйл ажиллагаандаа Монгол улсын "Үндсэн хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Компанийн тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай", "Хог хаягдлын тухай", "Эрчим хүчний тухай", хуулиуд болон Монгол улсын бусад холбогдох хууль, тогтоомж, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ИТХ-ын Зөвлөлийн тогтоол, аймаг, сумын Засаг даргын захирамж, үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөр, гэрээ болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулна.

1.3. Тус дүрмийн зорилго нь өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх, ашиглах зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.4. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ-ын өмчлөгч нь Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд төлөөлөн хэрэгжүүлэгч нь Сумын Засаг даргаас эрх олгосон ТҮК байна.

**ХОЁР. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ТҮҮТҮГ-ЫН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР**

2.1. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ-ын оноосон нэр нь "Бат-Өлзий сумын Тохижилт үйлчилгээ Улсын төсөвт үйлдвэрийн газар" байх бөгөөд товчилсон нэр нь "Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ" байна.

2.2. Оршин байгаа газар нь: Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум байна.

**ГУРАВ. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ТҮҮТҮГ-ЫН БИЛЭГДЭЛ ТЭМДЭГ**

3.1. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ нь өөрийн билэгдэл, барааны тэмдэгтэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

3.2. Билэгдэл, барааны тэмдгийн загварыг гүйцэтгэх захирал баталж, Улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлсэн байх бөгөөд түүний хэрэглэх эрхийг Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ өдөлнэ.

3.3. Тэмдгээр ТҮҮТҮГ-ын албан ёсны шийдвэр, албан бичиг гэрээ хэлцлийг баталгаажуулна.

3.4. Тэмдгийг ТҮҮТҮГ-ын гүйцэтгэх захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

ДӨРӨВ. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ТҮҮТҮГ-ЫН ЗОРИЛГО,

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

4.1. Бат-Өлзий сумын нийтийн үйлчилгээг үзүүлж, удирдан зохион байгуулагч нь "Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ" байна.

4.2. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ-ын зорилго нь орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, автозам, парк, хүүхдийн тоглоом, гүүр, засвар, үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх, шинэчлэлт хийх, ойн цэвэрлэгээнд гарах, хайрганы төвлөрсөн цэгтэй болох, сумын доторх такси үйлчилгээ, дээрх нийтийн үйлчилгээний чиглэлээр болон гэрэлтүүлэг, хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх, хамгаалах, хэвийн төлвийг тодорхойлох, ил болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ашиглалтанд хяналт тавих, төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг эрхлэх, нэгдсэн удирдлагаар хангах, өөрийн үйлдвэрийн автомашин механизмыг, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, хөрс үйлдвэрлэл, мод үржүүлэг, тавилгын засвар, үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар Бат-Өлзий сумын нийтийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэхэд оршино.

4.3. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ТҮҮТҮГ нь дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ.

Үүнд:

- 4.3.1. нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохижилт, усалгаа, чимэглэл, байгууллага, гэр хорооллын хаягжилт
- 4.3.2. Гудамж, зам талбайн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт, усалгаа гэх мэт бүх төрлийн үйлчилгээ
- 4.3.3. Цэцэрлэгт хүрээлэн, усан оргилуурын ашиглалт хамгаалалт
- 4.3.4. Автозам, замын байгууламжийн засвар, арчлалт болон өвлүүн улиралд авто явган замын хальтиргаа, гулгааг арилгаж аюулгүй байдлыг хангах
- 4.3.5. Автозамын урсгал, тусгаарлах хашааны арчлалт хамгаалалт
- 4.3.6. Явган замын арчлалт хамгаалалт
- 4.3.7. Хог хаягдлын ачилт, тээвэрлэлтийн нэгдсэн хяналт, хамтын удирдлага
- 4.3.8. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг хариуцах
- 4.3.9. золбин нохой, муурын устгал
- 4.3.10. Гэрэлтүүлгийн нэгдсэн удирдлага, хяналт, засвар
- 4.3.11. Мод үржүүлэг, урсэлгээ
- 4.3.12. нийтийн эзэмшлийн тавилгын засвар үйлчилгээ /үүний дотор тэмдэг, тэмдэглэгээ, урсгал тусгаарлах хайс, рекламын самбар, сандал, хогийн сав зэрэг багтана./
- 4.3.13. хөшөө дурсгалын цогцолборт газрын арчлалт, хамгаалалт
- 4.3.14. Баазын машин, механизм, техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ
- 4.3.15. Болзошгүй аюул аваар ослын үед хүн хүч, техникийн нөөцийн шуурхай зохицуулалт
- 4.3.16. Ойн цэвэрлэгээнд гарах
- 4.3.17. Хайрганы төвлөрсөн цэгтэй болох
- 4.3.18. Суман доторх такси үйлчилгээ, нийтийн тээвэр
- 4.3.19. ОНХС-аар хийгдэж буй ажилд хамтран оролцох



4.4. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ нь гадаад дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, түүнчлэн хуулийн байгууллагад нэхэмжлэгч, хариуцагчаар оролцно.

4.5. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ нь байгууллагын чадавхийг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, нийтийн эзэмшлийн эд аж ахуйг засварлах, шинэчлэх, нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулан ажиллана.

4.6. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ нь орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбай, автозам, барилга байгууламж, эд аж ахуйн засвар үйлчилгээг олон улсын түвшинд хүргэх, газраас бусад үйлчилгээний стандарт, барилгын норм дүрэм аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллах үүргийг хүлээнэ.

4.7. Төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хөлс, үнэ тарифыг сумын ИТХ-аар батлуулна.

4.8. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ нь орон нутгийн өмчит нийтийн эзэмшлийн зам талбай, авто зам, барилга байгууламж, эд аж ахуйг шинээр барих, шинэчлэлтийн ажлыг ашиглалтанд хүлээн авахад оролцож, саналаа илэрхийлэн акт, баримт бичигт холбогдох этгээд гарын үсг зурна.

4.9. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ нь өөрийн эрхлэх үндсэн үйл ажиллагааг өмчийн бүх төрлийн хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

4.10. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ нь үйлдвэрлэлийн болон тээвэр үйлчилгээний баазын материаллаг баазыг өргөтгэх, орчин үеийн тусгай зориулалтын шинэ техник технологийг нэвтрүүлэх, хүчин чадлыг нь бүрэн ашигласан хоёрдах түүхий эд боловсруулах үйлдвэрлэл үйлчилгээ явуулна.

4.11. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаараа сумын ИТХ, Зөвлөлийн тогтоол, сумын Засаг даргын захирамжийн төсөл боловсруулан гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих ажлыг зохион байгуулна.

4.12. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэнээс бусад тохиолдолд УТҮГ нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

#### ТАВ. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ТҮҮТҮГ-ЫН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ

5.1. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, хариуцлага хүлээнэ.

5.2. Бат-Өлзий сумын ТҮҮТҮГ нь эд хөрөнгийн талаар дараах эрх үүрэгтэй байна.

5.2.1. Өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах

5.2.2. ТҮҮТҮГ-ЫН үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас хуульд заагдсан татвар хураамжийг төлсний дараах цэвэр ашгийг байгууллагынхаа үйл ажиллагааг бэхжүүлэх болон ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулна.

5.2.3. Ажил үйлчилгээ үзүүлсэний үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативт хэмжээгээр үлдээж, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулна.

5.2.4. ТҮҮТҮГ нь үндсэн хөрөнгийг Аймгийн өмчийн хэлтэсийн шийдвэрийг үндэслэн акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах шилжүүлэх эрхтэй.

ЗУРГАА: УТҮГ-ЫН УДИРДЛАГА, УДИРДАХ ЗӨВЛӨЛ

6.1. УТҮГ-ЫН эрх барих байгууллага нь Удирдах зөвлөл байх бөгөөд, "Компани тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуульд заасан эрх, үүргийн дагуу Аймгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлнэ.



6.1.1. Удирдах зөвлөл нь УТҮГ-ын тухайн жилд хийгдэх их засварын нэгдсэн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн батална.

6.1.2. УТҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь Удирдах зөвлөлийн анхны хурлыг Удирдах зөвлөлийг сонгосноос хойш нэг сарын дотор хуралдуулах ажлыг зохион байгуулна.

6.1.3. Зайлшгүй нэмэлтээр хөрөнгө оруулалт хийх тохиолдолд саналаа тооцоо судалгаатайгаар боловсруулж удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн баттуулах ажлыг зохион байгуулна.

6.1.4. Удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдааныг зохион байгуулахдаа Компаний тухай хууль болон бусад хуулийг дагаж мөрдөнө.

6.1.5. Удирдах зөвлөл нь УТҮГ-ын үйл ажиллагааг хэвийн хэмжээнд явуулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг Аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулж шийдвэрлүүлнэ.

6.1.6. Гишүүд нь гүйцэтгэх удирдлага болон Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар дамжуулан өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичиг баримт, тайлан мэдээлэл зэргийг аман болон бичгээр авна.

6.2. Гүйцэтгэх захирал нь Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуульд заасан шалгуурыг хангасан байна.

6.3. Гүйцэтгэх захирал нь орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

6.4. Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг хуулийн хүрээнд тогтооно.

6.5. Гүйцэтгэх захирал нь дор дурдсан эрх үүрэгтэй байна.

6.5.1. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах

6.5.2. Сумын Засаг даргатай хийсэн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого үйл ажиллагааг зохион байгуулах

6.5.3. УТҮГ-ын эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллах

6.5.4. Ажил үүргээ гүйцэтгэх явцад олэ авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх

6.5.5. Аймгийн ИТХ, Засаг даргын баталсан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоох, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх

6.5.6. Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх хариуцлага, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулалт зэрэг асуудлыг хөдөлмөрийн гэрээнд тусгана.

6.6. Хууль тогтоомж болон гэрээгээрлгосон бусад эрх үүрэг.

6.6.1. Гүйцэтгэх захирал нь Аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, удирдах газрыг төлөөлөх зэргээр удирдах газрын нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа зохион байгуулна.

6.6.2. Гүйцэтгэх захирал нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

6.6.3. Гүйцэтгэх захирал нь өөрийн эрх үүргийг Удирдах зөвлөлтэй зөвшилцэн итгэмжлэлийн үндсэндээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

ДОЛОО. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН УТҮГ-ЫН ХЯНАЛТ



7.1. УТҮГ нь үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг захирал батална.

7.2. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулна.

7.3. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналт шалгалтыг нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

#### НАЙМ. УТҮГ-ЫН САНХҮҮГИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАН

8.1. УТҮГ нь санхүүгийн тайланг нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, тогтоомж, олон улсын нягтлан бodoх бүртгэлийн стандартын дагуу гаргаж аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

8.2. УТҮГ-ын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, нягтлан бодогч нар хариуцна.

8.3. УТҮГ-ын нягтлан бодогч нь бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байна.

8.4. УТҮГ-ын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөн оны 12-р сарын 31-ний өдөр дуусгавар болно.

#### ЕС. УТҮГ-ЫН МАНХҮҮЖИЛТ, САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

9.1. УТҮГ-ын орлого нь дараах эх үүсвэрээс бурдэнэ.

9.1.1 Улс, Аймаг, орон нутгийн төсвийн санхүүжилт

9.1.2 Ажил үйлчилгээнээс олсон бүх орлого

9.1.3. Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

9.2. УТҮГ-ын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана.

9.2.1. Баланс

9.2.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан

9.2.3. Мөнгөн гүйлгээний тайлан

9.2.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан

9.2.5. тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин шагнал урамшуулал

#### АРАВ. УТҮГ-ЫГ ТАТАН БУУЛГАХ

10.1. УТҮГ-ыг Бат-Өлзий сумын Засаг даргын саналаар Аймгийн ИТХ үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

#### АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА

11.1. Монгол Улсын хууль тогтоомж, аймаг, сумын ИТХурал, Зөвлөлийн тогтоол, Бат-Өлзий сумын Засаг даргын үндсэн чиглэлийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

#### АРВАН ХОЁР. БУСАД

12.1. Хуульд нийцүүлэн дүрэмд тусгаснаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.



12.2. УТУГ-ЫН ЭНЭХҮҮ ДҮРЭМ НЬ Монгол Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

